



**“АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ӨРГӨТГӨЛ”-ИЙН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар №ХЗДХЯ/202112001

2021 оны 04 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Нэг талаас Архивын ерөнхий газар, түүнийг төлөөлж Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар (цаашид “захиалагч” гэх), негээ талаас “Өгөөмөр-Уул” ХХК, түүнийг төлөөлж Барилгын инженер П.Эрдэнэ-Очир (цаашид “нийлүүлэгч” гэх) нар нь дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 04 дугаар сарын 02 -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино

2. Захиалагч нь Архивын ерөнхий газрын барилгын их засвар, өргөтгөл нэартэй, ХЗДХЯ/202112001 дугаар (цаашид “их засвар, өртгөтгөл” гэх)-тай 2 багцтай 1 тендерийг Багц 1 - 153,000,074 (нэг зуун тавин гурван сая далан дөрвөн) төгрөгөөр, Багц 2 – 124,000,014 (нэг зуун хорин дөрвөн сая арван дөрвөн) төгрөгөөр нийт 277,000,088 (хоёр зуун далан долоон сая наян найман) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь ажлын гүйцэтгэл 277,000,088 (хоёр зуун далан долоон сая наян найман) төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Гүйцэтгэгч нь Архивын ерөнхий газрын их засвар, өргөтгөлийн ажлыг 2021 оны 04 дугаар сарын 05-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор хийж гүйцэтгэн хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Техникийн тодорхойлолт

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ХЯНАСАН:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Л.ХОСБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ

А.МОНХБАЯР

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ,
АЖ АХУЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Х.ЦОГТБААТАР

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
21 дүгээр хороо, Утас: 77002099

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ,
АЖ АХУЙН ХЭЛТСИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭСГИЙН
АХЛАГЧ

С.НАРАНЧИМЭГ

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
21 дүгээр хороо, Утас: 77002050

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ӨГӨӨМӨР-УУЛ" ХХК-ИЙН БАРИЛГЫН
ИНЖЕНЕР

П.ЭРДЭНЭ-ОЧИР

Хаяг: Төв аймаг, Зуунмод сум 5-р баг,
Нацагдорж өөрийн байр, Утас: 99309116
91316666

"ӨГӨӨМӨР УУЛ" ХХК-ИЙН БАРИЛГЫН
ДААМАЛ

Ц. МААНИЙ

Төрийн банк: ДД:310000018527
Регистрийн дугаар:2032376